



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар A/22

Улаанбаатар хот

Хотын стандартын төсөл боловсруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 67 дугаар зүйлийн 67.5, Стандартчлал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹.1, 10¹.2, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21.1.3, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт 9.5, Газрын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.2; 7 дугаар зүйлийн 7.1.1; 7.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах, орчны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2022 онд шинээр боловсруулах хотын стандартын төслийн жагсаалт, хариуцах нэгжийн хувиарлалтийг хавсралтаар баталсугай.

2. Хотын стандартын баримт бичгийн ажлын даалгаврыг боловсруулах, зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллагуудын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Худалдаа үйлчилгээний стандартын хэлтэс (Н.Билэгсайхан), Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс (М.Цогтбилэг), Байгаль орчны стандартын хэлтэс (Д.Өлзийсайхан)-т тус тус даалгасугай.

3. Судалгааны ажилд зарцуулах 229,000,000 (Хоёр зуун хорин есөн сая) төгрөгийг ажил гүйцэтгэх гэрээ, акт, гэрээ дүгнэсэн тэмдэглэлд үндэслэн Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас гүйцэтгэлээр нь тооцож санхүүжүүлэхийг Ахлах няглан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Орлогч дарга (О.Оджаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500256